



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 2/426

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 29.1 "а" төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотоос тус аймаг руу нэвтрэх иргэдийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих үүрэг бүхий постод 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 61 хоногийн хугацаанд ажиллаж буй 4 алба хаагчдын хоол, шатахууны зардал, аймгийн төвд ажиллаж буй "тусгаарлах байр"-нд 2021 оны 8 дугаар сарын 02-ноос 2021 оны 8 дугаар сарын 31-нийг хүртэл 30 хоногийн хугацаанд харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын хоол, аймгийн "Шуурхай штаб"-т үүрэг гүйцэтгэж буй жижүүрийн алба хаагчдын хоолны зардлыг хавсралтаар баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 14,953,000 (арван дөрвөн сая есөн зуун тавин гурван мянга)-н төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231012025

Аймгийн Засаг даргын 2021 оны
09 дугаар сарын 09 өдрийн 4426
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Байгууллагын нэр	ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ				Дүн
		Шатхууны зардал	Чингис хаалга /7-01-8.31 дуустал 61 хоног/	Хоолны зардал шуурхай штаб /8-2/ 30 хоног, 5 хүн	Тусгаарлах байрны хоолны зардал /8.02/-8.31/ 30 хоног, 8 хүн	
1	Цагдаагийн газар	1,333,000	5,820,000			7,153,000
2	Онцгой байдлын газар			3,000,000	4,800,00	7,800,00
	Дүн	1,333,000	5,820,000	3,000,000	4,800,000	14,953,000